



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/129

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "б", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны "Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх тухай" тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.23 дугаарт батлагдсан Хөдөө аж ахуйг хөгжүүлэх малын үржил, селекцийг сайжруулах, цөм сүргийг эрүүлжүүлэх, хүлэмж барих (Өвөрхангай, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан) зарцуулах 200.000.000 (хоёр зуун сая) төгрөгийн төсөл, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100281

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 30-ны өдрийн 11/2020 дугаар
захирамжийн хавсралт



Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.23 дугаарт батлагдсан хөдөө аж ахуйг хөгжүүлэх малын үржил, селекцийг сайжруулах, цөм сүргийг эрүүлжүүлэх, хүлэмж барих /Өвөрхангай, Бат-өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан/-д зардлын хуваарилалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Хүлэмж барих зардал	50 000.0
2	Газар тариалангийн зориулалттай худаг гаргах зардал	60 000.0
3	Малын үржил селекцийг сайжруулах зардал	90 000.0
	НИЙТ ДҮН	200 000.0

-оОо-